

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг  
тогтворжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийн зээлийн  
шугамын 2 дахь ашиглалт гарлаа**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Энэ хүрээнд оролцогч банкаар дамжуулан анхны транчаар “Жаст ойл” ХХК-д 7.1 тэрбум төгрөгийг санхүүжилтийг 2012.11.27-ны өдөр олгосон бол **2 дахь транчаар “Монпетекс” ХХК-д жилийн 3.8%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай 8.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг өнөөдөр шилжүүллээ.**

Түүнчлэн дэд хөтөлбөрт заасны дагуу Монголбанк нь оролцогч банкаар дамжуулан “Монпетекс” ХХК-д **8.5 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг 2 сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар** гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Ингэснээр SIFS дэд хөтөлбөрийн зээлийн шугамаас өнөөдрийн байдлаар нийтдээ **15.6 тэрбум төгрөгийн ашиглалт** гараад байна.

Дэд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны “Үнийг тогтворжуулах хөтөлбөр” цэснээс үзнэ үү.  
<http://www.mongolbank.mn/pricestability.aspx>